



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

"Эрдэнэхайрхан хөгжил" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/001/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Х.Болдбаатар Утас: 99105506 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn</p> <p>Аудитор: О.Алтансүвд Утас: 88009224 Цахим хаяг: altansuvdo@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завахан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025. 02. 15 № 440
тшаг _____ -ны № _____ -т

“ЭРДЭНЭХАЙРХАН ХӨГЖИЛ”
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН-Д

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэхайрхан хөгжил” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлого үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад дүгнэлт өгөх аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол “Эрдэнэхайрхан хөгжил” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тодруулгад Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хувь хүнээс анхан шатны баримтгүй 2,719,200 төгрөгийн шатахуун худалдан авч, жолоочийн замын хуудасгүй, тооцоо бодолгүйгээр зарцуулсан, байгууллагын хөрөнгөөс 191,800.0 төгрөгөөр архи согтууруулах ундаа худалдан авсан, өөрийн хамаарал бүхий “Сүндэр эрдэнэ” ХХК болон иргэний дансаар 3,592,063 төгрөгийг дамжуулан зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7-т “байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана” гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

D:\disk\Анбан бичиг\Дүгнэлт-2025

217510001

"Эрдэнэхайрхан хөгжил" ОНӨААТҮГ нь тайлант онд шинээр эмийн сан болон 4 айлын орон сууцыг дулаанаар хангах гэрээ байгуулж, гэр хорооллын халаалтын шугамын зураг төслийг 30,000,000 төгрөгөөр хийлгэсэн байна.

Аудитын гол асуудал

"Эрдэнэхайрхан хөгжил" ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлого үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад дүгнэлт өгөх аудитаар Эрүүл мэндийн төвөөс халаалтын төлбөрийг гэрээний үнээс 1,147,700 төгрөгөөр илүү тооцож авсан, нүүрс тээврийн хөлсийг зах зээлийн ханшнаас хэт өндөр тооцож 6,987,400, төгрөгөөр илүү олгосон зөрчил илэрсэн байна.

Бусад асуудал

Байгууллагын 2024 оны жилийн эцсийн, эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулаагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	38,394,356.00	18,593,363.94
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	34,779,356.00	9,235,713.94
31211	Төрийн сангийн харилцах	34,779,356.00	9,235,713.94
33	АВЛАГА	00.00	2,570,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	500,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	2,070,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,615,000.00	6,787,650.00
35410	Бичиг хэргийн материал	22,500.00	49,150.00
35420	Аж ахуйн материал	1,150,000.00	3,497,350.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	173,800.00
35440	Түлш, шатах тослох материал	600,000.00	1,224,850.00
35470	Бусад хангамжийн материал	1,842,500.00	1,842,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	14,319,211.13	12,851,944.49
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,319,211.13	12,851,944.49
392	Биет хөрөнгө	13,043,211.13	11,839,944.49
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,153,000.00	5,598,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-426,122.21	-1,603,055.57
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,110,000.00	11,110,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-793,666.66	-3,264,999.94
393	Биет бус хөрөнгө	1,276,000.00	1,012,000.00
39301	Програм хангамж	1,320,000.00	1,320,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-44,000.00	-308,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	52,986,167.13	31,445,308.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,000.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	11,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	52,975,167.13	31,445,308.43
51	Засгийн газрын хувь оролцоо	52,975,167.13	31,445,308.43
51220	Тайлант үеийн үр дүн	52,975,167.13	31,445,308.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	52,986,167.13	31,445,308.43

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	255,324,881.76	262,391,878.31
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	202,622,314.63	283,649,137.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	89,280,562.00	114,682,679.00
210101	Үндсэн цалин	89,280,562.00	114,682,679.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,257,750.54	12,322,770.82

210201	Тэтгэврийн даатгал	9,686,529.54	7,744,937.82
210202	Тэтгэмжийн даатгал	714,244.00	1,448,387.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	178,561.00	640,252.00
210204	Ажилгүйдлийн даатгал	892,806.00	444,585.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,785,610.00	2,044,609.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,680,479.30	41,730,700.60
210301	Гэрэл, цахилгаан	15,003,554.30	18,350,863.10
210302	Түлш, халаалт	62,676,925.00	21,579,837.50
210304	Байрны түрээс	00.00	1,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,204,456.00	35,342,290.00
210401	Бичиг хэрэг	29,500.00	55,600.00
210402	Тээвэр, шатахуун	2,331,506.00	33,478,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	170,000.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,673,450.00	1,608,290.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,935,277.92	57,075,309.93
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,785,467.00	57,037,840.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	149,810.92	37,469.93
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,263,788.87	22,295,386.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	18,383,120.02
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	1,263,788.87	3,912,266.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	200,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	52,702,567.13	-21,257,258.70
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	52,702,567.13	-21,257,258.70

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	22,000.00	52,702,567.13	00.00	52,724,567.13
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	22,000.00	52,702,567.13	00.00	52,724,567.13
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-21,257,258.70	00.00	21,257,258.70
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	22,000.00	31,445,308.43	00.00	31,467,308.43

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	255,324,881.76	259,821,878.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	204,962,525.76	282,920,520.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	89,269,562.00	114,682,679.00
210101	Үндсэн цалин	89,269,562.00	114,682,679.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,257,750.54	12,333,770.82
210201	Тэтгэврийн даатгал	9,686,529.54	12,333,770.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,280,479.30	42,355,550.60
210301	Гэрэл, цахилгаан	15,003,554.30	18,350,863.10
210302	Түлш, халаалт	63,276,925.00	22,204,687.50
210304	Байрны түрээс	00.00	1,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,376,956.00	35,480,290.00
210401	Бичиг хэрэг	52,000.00	82,250.00
210402	Тээвэр, шатахуун	2,331,506.00	33,478,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	170,000.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,823,450.00	1,719,640.00
2105	Нормативт зардал	1,842,500.00	2,200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,842,500.00	2,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	209,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	209,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,935,277.92	57,075,309.93
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,785,467.00	57,037,840.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	149,810.92	37,469.93
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	18,383,120.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	18,383,120.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	200,000.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	50,362,356.00	-23,098,642.06
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	236,128,525.76	2,445,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	236,128,525.76	2,445,000.00
222001	Тоног төхөөрөмж	15,583,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	220,545,525.76	2,445,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-236,128,525.76	-2,445,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-185,766,169.76	-25,543,642.06
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	34,779,356.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	34,779,356.00	9,235,713.94

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	2024оны төлөвлөгөө	2024 оны гүйцэтгэл	Зөрүү
1	Цалин	114,682,000.0	114,682,000.0	0.00
2	НДШ	12,322,000.0	12,322,000.0	0.00
3	Гэрэл цахилгааны зардал	18,350,000.0	18,350,000.0	0.00
4	Түлш, халаалт	21,579,000.0	21,579,000.0	0.00
5	Бараа материал	1,880,000.0	1,880,000.0	0.00
6	Албан татвар зардал	18,383,000.0	18,383,000.0	0.00
7	Байрны түрээс	1,800,000.0	1,800,000.0	0.00
8	Бичиг хэрэг	55,000.0	55,000.0	0.00
9	Тээвэр шатахуун	33,478,000.0	33,478,000.0	0.00
10	Гэр интэрнет төлбөр	200,000.0	200,000.0	0.00
11	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	57,037,000.0	57,037,000.0	0.00
12	Банк санхүүгийн байгуулага хураамж	37,000.0	37,000.0	0.00
13	Үндсэн хөрөнгийн элэгдэл	3,912,000.0	3,912,000.0	0.00
14	Тэтгэмж зардал	200,000.0	200,000.0	0.00
Нийт дүн		283,915,000.0	283,915,000.0	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа

"Эрдэнэхайрхан хөгжил" ОНӨААТҮГ-ын Халаалт болон бусад үйл ажиллагааны орлогоор санхүүжих замаар сумын ард иргэдэд нийтийн үйлчилгээг үзүүлэх Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар юм.

3.2 Компани/ ОНӨААТҮГ -ын гадаад, дотоод орчин

"Эрдэнэхайрхан хөгжил" ОНӨААТҮГ нь үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Хөдөлмөрийн

тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

"Эрдэнэ хайрхан хөгжил" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

"Эрдэнэ хайрхан хөгжил" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21.2 сая төгрөгөөр буюу 40.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	34,779.30	9,235.70	-25,543.60
Авлага	0	2,570.00	2,570.00
Урьдчилж төлсөн зардал	0	0	0.00
Бараа материал	3,615.00	6,787.60	3,172.60
Үндсэн хөрөнгө	14,319.20	12,851.90	-1,467.30
Нийт хөрөнгө	52,713.50	31,445.20	-21,268.30
Өр төлбөр	11	0	-11.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	52,702.50	31,467.30	-21,235.20
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	52,713.50	31,445.20	-21,268.30

Дээрх хүснэгтээс харахад данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

- Мөнгөн хөрөнгө өмнөх оноос 25.5 сая төгрөгөөр буурсан нь цалингийн зардал өссөн, айл өрхөөс төвлөрүүлэх халаалтын төлбөр дутуу төвлөрүүлсэнтэй холбоотой байна.
- Авлага өмнөх оноос 2.5 сая төгрөгөөр өссөн нь айл өрхүүд халаалтын төлбөрийг дутуу төлсөнтэй холбоотой байна.
- Бараа материалын хөрөнгийн үлдэгдэл өссөн нь тайланд онд 33.6 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 30.5 сая төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл буурсан нь тайлант онд 2.4 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, хөрөнгийн элэгдлийн зардал 3.9 сая төгрөгөөр тооцсон зэрэгтэй холбоотой байна.
- Өр төлбөр өмнө оноос 204.8 сая төгрөгөөр өссөн нь зам арчлалтын санхүүжилт оройтож орж ирсэнтэй холбоотой байна гэж үзлээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

"Эрдэнэ хайрхан хөгжил" ОНӨААТҮГ нь 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталаагүй байна.

"Эрдэнэ хайрхан хөгжил" ОНӨААТҮГ нь тайлант онд 259.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, өмнөх онтой харьцуулахад 4.5 сая төгрөгөөр өсөж, 282.9 сая төгрөгийн зардал гарган, 21.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэ нь гэр хорооллын халаалтын шугамын зураг төслийг 30.0 сая төгрөгөөр хийлгэж ажилчдын цалинг хөлсийг нэмэгдүүлсэн зэрэгтэй холбоотой байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу "Эрдэнэ хайрхан хөгжил" ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх ОНӨААТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг сайжруулах нягтлан бодох бүртгэл, төсвийн зарцуулалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Алтансүвд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

"Эрдэнэ хайрхан хөгжил" ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайланг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 19 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 283,649.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 5,672.9 сая төгрөгөөр тогтоосон байна.

Материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт 283,649.1 сая төгрөгийн 2 хувь буюу 4,254.7 сая төгрөгөөр дахин тооцооллоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 20 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлэхэд "Эрдэнэ хайрхан хөгжил" ОНӨААТҮГ нь 191.8 мянган төгрөгөөр согтууруулах ундаа худалдан авч, тус хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.7-т "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах" гэж заасныг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоосон.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

"Эрдэнэ хайрхан хөгжил" ОНӨААТҮГ нь Шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд тухай бүр мэдээлээгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зерчил илрээгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

"Эрдэнэ хайрхан хөгжил" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх онд санхүүгийн тайлангийн аудитаар хийгдээгүй.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж					
Нийт дүн					

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үзэх эрсдэлтэй асуудал байхгүй байна гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 44,755.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 10,477.4 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 4,058.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 10,579.5 мянган төгрөгийн албан шаардлага, жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг хийгээгүй 19,639.5 мянган төгрөгийн болон Байгууллагын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталаагүй, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд 3 заалт зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа: Тайлант онд үүссэн 2,570.0 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй, мөнгөн гүйлгээний тайланд 7,907.4 мянган төгрөгийг зардлыг зөв ангилж бүртгээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" 8 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасан, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-тай нийцэхгүй, ангилал, толилуулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

5.1 Төлбөрийн акт:

Хувь хүнээс анхан шатны баримтгүй 2,719.2 мянган төгрөгийн шатахуун худалдан авч, жолоочийн замын хуудасгүй, тооцоо бодолгүйгээр зарцуулсан, байгууллагын хөрөнгөөс 191.8 мянган төгрөгөөр архи согтууруулах ундаа худалдан авсан, Эрүүл мэндийн төвөөс халаалтын төлбөрийг гэрээний үнийн дүнгээс 1,147.7 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага:

Нүүрс тээврийн хөлсийг зах зээлийн ханшнаас хэт өндөр тооцож 6,987.4 мянган төгрөгийг илүү олгосон, өөрийн хамаарал бүхий "Сүндэр эрдэнэ" ХХК болон Д.Номин-Эрдэнэ нарын дансаар 3,592.1 мянган төгрөгийг дамжуулан зарцуулсан нийт 10,579.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй” гэж зассантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулж байх;

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын 2024 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг хийгээгүй 19,639.5 мянган төгрөгийн зөрчил байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-д "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 12 дугаар зүйлийн 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 12.2.2-д "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", 12.2.3-д "эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн үед", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэгтэй" гэж зассантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд үнэн зөв хийж, үр дүнг тооцож, үлдэгдлийг баталгаажуулан, баримтжуулж байх;

3. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны цахим мэдээллийн санд холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд тухай бүр мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор "shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй" зассантай нийцэхгүй, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд холбогдох байгууллагын төсөв санхүүтэй холбоотой мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, иж бүрэн мэдээлж хэвших;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Нийт илрүүлсэн 34,277.7 мянган төгрөгийн зөрчлөөс 19,639.5 мянган төгрөгийн зөрчлийг шинж чанарын хувьд материаллаг гэж үзэн, 14,638.2 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант онд үүссэн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй	1	2,570.0	1	2,570.0			1	2,570.0				
Мөнгөн гүйлгээний тайланд зардал буруу бүртгэсэн	1	7,907.4			1	7,907.4						
Дүн	2	10,477.4	1	2,570.0	1	7,907.4	2	10,477.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТТ	Тоо	Дүн
Анхан шатны баримтгүй хувь хүнээс шатахуун худалдан авч, төлбөрийг шилжүүлсэн	1	2,719.2	1	2,719.2								
Эрүүл мэндийн төвөөс халаалтын төлбөр илүү тооцож авсан.	1	1,147.7	1	1,147.7								
Архи согтууруулах ундаа худалдаж авсан.	1	191.8	1	191.8								
Өөрийн хамаарал бүхий "Сүндэр эрдэнэ" ХХК болон Д.Номин-Эрдэнэ нарын дансаар 3,592.0 мянган төгрөгийг дамжуулан зарцуулсан.	1	3,592.0			1	3,592.0						
Нүүрс тээврийн хөлсийг зах зээлийн ханшнаас хэт өндөр	1	6,987.4			1	6,987.5						

Тооцож олгосон.																			
Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийж тооцоо бодоогүй.	1	19,639.5				1				19,639.5									
Дүн	6	34,277.7	3	4,058.7	1	10,579.5	1			19,639.5									

Санхүүгийн тайлангийн аудитгаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Мянган мөгрөөвөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Шилэн дансны цахим мэдээллийн санд холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд тухай бүр мэдээлээгүй байна	1	0					1	0
Дүн	1	0					1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Байгууллагын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилгот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталаагүй байна.	1	0					1	0
Дүн	1	0					1	0
Нийт дүн	2	0					2	0

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА
 АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Огноо: 2025-03-12

О.АЛТАНСУВД

